

**МОНГОЛ УЛСАД МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХАЯГ, ХАЯГИЙН БИЧВЭРТЭЙ
ХОЛБОГДОХ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ
ХУУЛЬ, ТОГТООМЖ, СТАНДАРТ**

1. “Хаягжуулалтын тухай” Монгол улсын хууль /2013-02-1/-д:

Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад баритлах зарчмыг тогтоож өгсөн байна.

2. Бүсчлэлийн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам/Засгийн газрын тогтоол №200, 2007 он/

Энэхүү тогтоолоор “Бүсчлэлийн код”, “Мэдээллийн сан”, “ Хаягийн бүс”-ийг тодорхойлж, бүсчлэлийн кодыг нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулсан хавсралтыг баталсан байдаг.

3. MNS 5880:2008 Шуудангийн нэгдсэн кодын формат. Ерөнхий шаардлага

Энэ стандартаар шуудангийн илгээмжийн хаягт эзний хаягийн байршлыг тоон өгөгдлөөр илэрхийлэхэд тавих шаардлагыг тогтоон, нэгдсэн кодын илэрхийлэл, форматыг тодорхойлсон байдаг.

4. MNS 5971:2009 Шуудангийн хаяг

Энэ стандартаар дотоодын болон улс хоорондын шуудангаар үйлчлүүлэгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хаягийг тодорхойлох ба түүнд агуулагдах мэдээлэл, бүтцийг тогтоосон.

5. MNS MNS 6275 : 2016 Нэгдсэн хаягжуулалт. Хаягийн бичвэрт тавих шаардлага

Энэ стандартаар дотоодын болон олон улсын хэмжээнд ашиглагдах төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн харьяаллын, байршлын болон шуудангийн хаягийг тодорхойлох ба хаягийн бичвэрт тавигдах шаардлага, агуулагдах мэдээлэл, бүтцийг тогтоосон.

6. Дотоод шуудангийн үйлчилгээ, илгээмжийн хаягийн гарын авлага

Энэхүү гарын авлага нь шуудангийн хаяг, тэмдэглэгээг хэрхэн хэрэглэх зааврыг дэлгэрэнгүй боловсруулж, хаяг бичих боломжит хувилбаруудыг жишээгээр тайлбарласан байдаг.

7. Standardized address format description (SAFD)/ Mongolia.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос хүргүүлсэн хүсэлт, мэдээллийг үндэслэн ДШХ-ноос UPUS42-ын форматыг Монгол улсын шуудангийн хаягийн

бичвэрт нийцүүлсэн стандарт хаягийн форматын тайлбар, бичвэрийг ирүүлсэн байна.

Дээр дурьдсан баримт бичгүүдийг судалж үзэхэд MNS 5880:2008 Шуудангийн нэгдсэн кодын формат. Ерөнхий шаардлага стандартын формат хэсгээс бусад нь кодыг үүсгэх, олгохтой холбогдсон ХХЗХ-ны чиг үүргийг тодорхойлсон байна.

MNS 5971:2009 Шуудангийн хаяг, MNS MNS 6275 : 2016 Нэгдсэн хаягжуулалт. Хаягийн бичвэрт тавих шаардлага стандартуудын нэг төрлийн нэр томъёог өөр өөрөөр тодорхойлсон, хаягийн бичвэрт тавигдах шаардлагууд давхардсан, хаягийн бичвэрийн стандартын зарим нэр томъёоны тодорхойлолтууд MNS 5880:2008-тэй давхардсан зөрчилдсөн тохиолдлууд нилээдгүй байгаа нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос “Шуудангийн хаягийн бичвэрийн стандартыг S42-той нийцүүлэн шинэчлэх ажлын даалгаврын шаардлагатай нийцэж байна.

Гэхдээ Дэлхийн шуудан холбооноос ирүүлсэн Standardized address format description (SAFD)/-д дурьдсан хаягийн элемент, хаягийн бүтцийн үг үсгийн зөв орчуулгын талаар стандартад ХХЗХ-ны мэргэжилтний санал, зөвлөмжийг авч тусгах шаардлагатай юм.

ХАЯГЖИЛТЫН ТАЛААРХ ХУУЛЬ, ТОГТООМЖ СТАНДАРТЫН УТГА АГУУЛГА ДАВХАРДСАН БУЮУ ИЖИЛ ЗААЛТУУДЫГ ЗЭРГЦҮҮЛСЭН ХҮСНЭГТ

Хаягжуулалтын тухай хууль/2013-02-15/	Бүсчиллийн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам /Засгийн газрын 2007 оны 200-р тогтоол/	Шуудангийн НК-ын формат 5880:2008	Хаягийн бичвэрт тавигдах шаардлага 6275:2016	Шуудангийн хаяг 5971:2009
<p>Хаягжуулалтын зарчим</p> <p>3.1.Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад дараах зарчим баримтална:</p> <p>3.1.1.байр зүйн зурагт суурилсан байх;</p> <p>3.1.2.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт нийцсэн байх;</p> <p>3.1.3.хаяг давхардахгүй байх;</p> <p>3.1.4.хаяг үнэн зөв, энгийн, ойлгомжтой байх;</p> <p>3.1.5.кадастрын бүртгэлээр баталгаажсан байх;</p> <p>3.1.6.хаягжуулах</p>	<p>2.1. "Бүсчиллийн код (зип код*)" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүсчиллийн хуваарийн дагуу засаг захиргааны нэгжийн болон хот суурингийн хэсэг (бүс)-ийн байршлын тухай мэдээллийг агуулж, тэдгээрийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан зохицуулалт хийх боломж бүхий нөөцтэй 5 оронтой цифрээр илэрхийлэгдсэн Монгол Улсын шуудангийн нэгдсэн кодыг;</p> <p>"3.1.10. "шуудангийн нэгдсэн код" гэж үйлчлүүлэгчийн байршлыг тодорхойлсон тоо болон үсэг, тооны хосолсон илэрхийллийг;/Шуудангийн тухай хууль/</p>	<p>4. Шуудангийн нэгдсэн код Шуудангийн нэгдсэн кодыг шуудангаар үйлчлүүлэгчийн хаягийн байршлыг тоогоор буюу үсэг, тоо хосолсон хэлбэрээр илэрхийлсэн дээд тал нь 9 орон бүхий дугаараар илэрхийлнэ.</p> <p>Шуудангийн нэгдсэн код нь угтвар код+хэсгийн код+дэд хэсгийн кодоос бүрдэнэ.</p> <p>Угтвар код гэж MNS 5461-1:2006 стандартын 5.3, 5.4-р заалтуудад заасан бүсийг илэрхийлсэн эхний 2 оронг;</p> <p>Хэсгийн код гэж "Бүсчлэлийн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам"-ын 2.1, 2.3-р заалтуудаар тодорхойлсон сүүлийн 4 оронг;</p> <p>Дэд хэсгийн код гэж хаягийн бүс доторх объект буюу хуулийн этгээдэд олгосон өргөтгөл дугаарыг хэлэх бөгөөд дээд тал нь дөрвөн оронгийн хязгаартайгаар үүсгэж болно.</p>	<p>3.4 шуудангийн хаяг шуудангаар үйлчлүүлэгч /хүлээн авагч ба илгээгч/-ийн гадаад ба дотоод шуудангийн илгээмж дээр бичихэд /илгээмжийг хүргэхэд/ зориулагдсан хаягийн бичвэр /зарим тохиолдолд байршлын хаягтай ижил байж болно/;</p> <p>3.5 хаягийн элемент иргэн, хуулийн этгээдийн хаягийн бичвэрт байх шаардлагатай бие даасан нэгж мэдээлэл;</p> <p>3.7 бүсчлэлийн /ЗИП/ код Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн хуваарийн дагуу засаг захиргааны нэгжийн болон хот суурингийн хэсэг (бүс)-ийн байршлын тухай</p>	<p>3.1.Шуудангийн хаяг аливаа эргэлзээгүй, эрэх, хайх шаардлагагүйгээр шуудангийн илгээмжийг хүргэх зорилготой, шуудангаар үйлчлүүлэгчийн оршин байгаа газрын байршил, хүлээн авагч болон илгээгчийн талаарх бичгийн хэлбэрээр илэрхийлсэн товч тодорхой, нарийвчилсан мэдээлэл</p> <p>3.4. хаягийн талбай шуудангийн илгээмжийг илгээгч болон хүлээн авагчийн шуудангийн хаяг бичихэд зориулсан талбай</p> <p>3.5. хаягийн элемент шуудангийн хаягийн бүтцэд зайлшгүй хамаарах мэдээллийн нэгж</p>

ажил нэгдсэн арга зүйтэй байх;

3.1.7. хаягийн талаарх мэдээлэл хүртээмжтэй, нээлттэй байх.

мэдээллийг агуулж, тэдгээрийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан зохицуулалт хийх боломж бүхий нөөцтэй, 5 оронтой тоон илэрхийлэл;

3.8

шуудангийн код

ЗИП кодын араас объектын байршлыг заасан 4 оронтой тоог залгуулан бичсэн 9 оронтой тоон илэрхийлэл;

4 Хаягийн төрөл

Хаяг нь дараахь 3 төрөлтэй байна.

6.1. Шуудангийн хаяг нь хувь хүний, албаны гэсэн 2 ангилалтай байна.

Тайлбар: Утга агуулга давхардсан заалтуудыг нэг ижил өнгөөр үзүүлэв.